



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 1/06

Улаанбаатар хот

**Дотоодын сургалтыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдыг тасралтгүй сургах, мэдлэгийг нэмэгдүүлж, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 2024 оны 3 дугаар сард зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулахдаа сургалтын удирдамжийг батлуулж, сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн тестийг авч дүгнэлт хийх, зохион байгуулсан сургалтыг тайланг тухай бүр гаргаж тайлагнаж ажиллахыг сургалт зохион байгуулсан ажилчдад үүрэг болгосугай.

3. Дотоодын сургалтанд хуваарийн дагуу бүрэн хамрагдахыг бүх ажилчдад үүрэг болгосугай

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг), Хүний нөөц, Дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)- нарт даалгасугай.

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 02 дугаар сарын 21 -ны өдрийн
5/06 тушаалын хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ДОТООДЫН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО:

Байгууллагын ажилчдын тогтвортой байдлыг хангаж, ажилтныг ажлын байранд дадлагажуулан сургах, ажилчдын мэдлэгийг нэмэгдүүлж, ур чадварыг дээшлүүлэх, чадварлаг байх нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх, холбогдох дээд шатны байгууллагаас гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангахад оршино.

ХҮРЭХ ҮР ДҮН:

- Байгууллагын ажилчдад зориулсан дотоодын сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.
- Сургалтыг зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөө нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр гаргах, үйл ажиллагааг тогтмолжуулсан байх
- Ажилчдын илтгэх, өөрийгөө илэрхийлэх ур чадварыг дээшлүүлэх
- Ажлын байранд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар хяналтыг тавьж ажиллах.

ЗОХИОН БАЙГУУЛАХ:

- Төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах ажилтан 5-7 хоногийн өмнө сургалтын удирдамжийг боловсруулж байгууллагын даргаар батлуулна.
- Сургалтын материалыг бэлтгэх удирдах ажилтнаар 2-3 хоногийн өмнө хянуулсан байна.
- Сургалтаар олгох мэдлэгийн тестийг боловсруулсан байна.
- Мэдлэгийн тестийг сургалтын өмнө боон хойно гэж 2 удаа авч сургалтын үр дүнг тооцож тайланг тусгана.
- Зохион байгуулсан сургалтыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийг удирдлагад танилцуулах
- Сургалтын үр дүнг тооцож хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина.
- Сургалтыг зохион байгуулсны дараа дараа 7 хоногийн даваа гариг гэхэд удирдамж, бүртгэл, сургалтын материал, мэдлэгийн тест, хийсэн ажлын товч тайлан зурагтай баталгаажуулан Хүний нөөц, дотоод хяналтын ажилтанд хүлээлгэн өгнө.

ДОТООДЫН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Сургалтын нэр	Сургалт зохион байгуулах огноо	Сургалтыг зохион байгуулах ажилтан
1.	Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам	2024.02.29	Мэдрэлийн эмч Б.Цэрэнчимэг
2.	Унах эрсдэлээс сэргийлэх журам		
3.	Эрэмбэлэн ангилал	2024.03.07	Дүрс оношилгооны эмч Г.Оюундулам Туслах сувилагч Т.Эрдэнэшүр
4.	Амилуулах суурь тусламж		
5.	Гар угаах, халдваргүйжүүлэх дараалал заавар		
6.	Түргэн тусламжийн журам	2024.03.14	Их эмч О.Номиндалай
7.	Яаралтай тусламжийн журам		
8.	Эмийн гаж нөлөө бүртгэх журам	2024.03.28	Эм найруулагч Д.Дашдулам Архив, бичгийн ажилтан Б.Арвижих
9.	Албан хэрэг хөтлөлтийн стандарт		

- Цагийн үеийн холбогдолтой мэдээлэл хүргэх сургалтуудыг тухай бүр зарлаж зохион байгуулна.
- Дотоодын сургалтанд ажилчид удирдамжийн дагуу бүрэн хамрагдана.